



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд нэмж гаргаж буй
энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 565,218 /таван зуун жаран таван мянга хоёр зуун арван найм/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн, тус компанийн нийт гаргасан хувьцааг 833,436 /найман зуун гучин гурван мянга дөрвөн зуун гучин зургаа/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Дөлгөөн/-т үүрэг болгож, нэмж гаргаж буй энгийн хувьцааг үнэт цаас гаргагчийн тодорхойлсон хувьцаа эзэмшигчийн өмчлөлд зохих журмын дагуу бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг “Блюскай секьюритиз ҮЦК” ХК /А.Ариунтуяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН

